



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/44

Номгон

Эрдэнэцогт нэгдэл ХХК-ийн газар
эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Газрын тухай хуулийн 40.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Эрдэнэцогт нэгдэл" ХХК нь эзэмшил газраа зориулалтын дагуу ашиглаагүй 2-оос дээш жил болсон тул газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосугай.

2.Газартай холбоотой мэдээллийг хавсралтаар баталсугай.

3.Газар эзэмших эрхийн гэрчилгээ хүчингүй болсонтой холбогдуулан мэдээллийг иргэнд мэдэгдэж, Цахим системд өөрчлөлт оруулж гэрээг цуцлахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т үүрэг болгосугай.

4.Захиргааны Ерөнхий хуулийн дагуу газар эзэмшигч иргэнтэй Сонсох ажиллагаа явуулсныг дурдаж хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд 30 хоногийн хугацаанд дээд шатны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэйг дурдсугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн Хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Энхбаяр)-т даалгасугай.

ДАРГА

Э.ЭНХБАТ



626010103

Аймгийн Засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 28-ны
өдрийн А/470 дүгээр захирамжийн хавсралт



ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ

Газар эзэмшигчийн мэдээлэл							
№	Хуулийн этгээдийн Нэр	Регистрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Газар эзэмших эрх олгосон захирамжийн огноо, дугаар	Нэгж талбарын хаяг, байршил	Газрын хэмжээ (м.кв-аар)	Газар ашиглалтын зориулалт
1	2	3	4	5	6	7	8
1	"Эрдэнэцогт нэгдэл" ХХК	3126269	6409008439	2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/470 дугаар захирамж	Баянхонгор сум, Гэгээн шавь 6-р баг, Гандангийн гудамж-1, 1016 тоот	700	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор

---oOo---